ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 22 өдөр Дугаар А/10 Арвайхээр сум

## Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5.1, Төрийн албаны зөвлөлийн "Зөвшөөрөл олгох тухай" 2023 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн 266 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн зөвшөөрлийг үндэслэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн, соёлын хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар батaлсугай.

2.Албан тушаалын тодорхойлолтын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга (С.Шийлэгцэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.ӨСӨХ-ЭРДЭНЭ

Аймгийн Соёл, урлагийн газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
А/10 дугаар тушаалын хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Өвөрхангай аймаг Соёл урлагийн газар | Захиргаа, удирдлагын хэлтэс |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл** |
| Ахлах мэргэжилтэн, соёлын хяналтын улсын байцаагч | Дэс түшмэл, ТЗ-6 |
| **Ажлын цаг** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| Ажлын өдөр 8 цаг | Пүрэвдоржийн гудамж Соёл урлагийн газар 5-р хороо, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандарт зөрчигдөх, болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хяналт шалгалт хийн, зөрчлийг шалган шийдвэрлэж, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэл үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

**Албан тушаалын зорилт:**

1. Соёлын хяналтын чиглэлээр хяналт шалгалтын бодлогыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх,
2. Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд соёлын салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, зөрчлийг шалган шийдвэрлэх;
3. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага,оролцооны хэлбэр<br>Туслах - Т,<br>Гүйцэтгэх-Г<br>Хянах - Х<br>Шийдвэрлэх - Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Хяналтын төв байгууллагаас баталсан бодлого, төлөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх, тайлагнах | Бодлого, төлөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлсэн байна. | Г |
| | 2.Хариуцсан хяналтын чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, эрх зүйн орчны боловсронгуй болгох болон тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээг авах: | Салбарын хяналт шалгалтын ажлыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг дээшлүүлсэн байна. | Г |
| | 3.Хариуцсан хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудсыг боловсронгуй болгох санал өгөх, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэх | | Г |
| | 4.Соёлын хяналтын чиглэлээрх байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн хэрэглээ, үйлчилгээний соёл, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбарын сургалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, иргэд, соёл, урлагийн байгууллагуудыг мэдээлэл, зөвлөмжөөр хангах | | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | 5.Цаг үеийн шинжтэй болон онцгой нөхцөл байдалд зохих журмын дагуу ажиллах | | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Соёлын хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, шалгалтын ажлын хэсэгт орж ажиллах, хяналт шалгалтын баримт бичиг үйлдэх; | Хяналт шалгалт бүрэн гүйцэт хийгдсэн байна. | Г |
| | 2.Ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хор хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 3.Соёл, урлагийн байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, соёлын өв, эд хөрөнгийг акт үйлдэж, улсын орлого болгох, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 4.Улсын байцаагчийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд түүнийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, ажил, үйлчилгээг түр эсхүл бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 5.Улсын байцаагчийн бусад нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 6.Холбогдох байгууллагатай тохиролцон зохих соёлын ажилтан, шинжээчийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргуулах; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 7.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлэх. | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, журмын | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | | дагуу явуулсан байна. | |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Сар, улирал, жилийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлийн гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах; | Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна | Г |
| | 2.Бодлогын баримт бичигт тусгагдсан соёлын хяналтын чиглэлд хамааралтай зорилт, арга хэмжээний биелэлтийг орон нутгийн соёлын хяналтын байцаагчаар гаргуулан авч нэгтгэн танилцуулах; | | Г |
| | 3.Холбогдох асуудлаар ажлын хэсэг, комисс зэрэгт ажиллах; | | Г |
| | 4.Иргэн, аж, ахуйн нэгж, байгууллага, соёл, урлагийн байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, шийдвэрлүүлэх; | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | Г |
| | 5.Хяналтын газрын үйл ажиллагааны болон хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах; | Олон нийтэд сурталчилсан байна. | Г |
| | 6. Холбогдох төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцох; | Хамтын ажиллагаа өргөжсөн байна. | Г |
| | 7.Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах; | Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна. | Г |
| | 8.Архив, албан хэрэг хөтлөлтийг зохих заавар, журмын дагуу хэрэгжүүлэх; | Заавар, журам, стандартад нийцсэн байна. | Г |
| | 9. Хууль, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | Шаардлагын түвшинд хэрэгжүүлсэн байна. | Г |

| | |
|---|---|
| **III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА** | |
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |

<table>
<tr><td>Мэргэжил</td><td colspan="2">- урлаг /021/<br>- хүмүүнлэг (хэлнээс бусад) /022/<br>- урлаг, хүмүүнлэгт хамаарах салбар дундын чиглэл /028/<br>-сэтгүүл зүй, мэдээлэл /032201, 032203/<br>- нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан /031401, 031404/<br>-боловсрол /011430/<br>- эрх зүй /042/<br>- менежмент, соёл, урлагийн<br>Соёл судлал /0310314/, археологи /022202/, музей судлал/0310314/, номын сан судлал /0320322/, түүх /022201/, хүн судлал /0310314/, урлаг судлаач /0220218/, урлагийн боловсрол /011418/, багш, монгол хэл- уран зохиолын боловсрол/0110114/, эрх зүйч /042101/.</td></tr>
<tr><td>Мэргэшил</td><td colspan="2">-</td></tr>
<tr><td>Туршлага</td><td colspan="2">Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.</td></tr>
<tr><td rowspan="2">Ур чадвар</td><td>Дүн шинжилгээ хийх</td><td>- Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх<br>- Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах<br>- Судлагааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй<br>- Хяналт шалгалтын цахим систем дэх мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлан, дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргахад ашиглах;<br>- Соёлын хяналт шалгалтын обьектын эрсдэлийн үнэлгээний мэдээлэл болон хяналт шалгалтын дүнд дүн шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах;<br>- Бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй санал боловсруулах;<br>- Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаварыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;<br>- Бусад.</td></tr>
<tr><td>Асуудал шийдвэрлэх</td><td>- Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах<br>- Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах<br>- Тулгамдаж буй асуудлыг судлах, арга хэмжээний санал, шийдлийг боловсруулж удирдлагад танилцуулах;<br>- Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах;<br>- Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга замыг оновчтой тодорхойлж, шийдвэрийн төсөлд тусгах;<br>- Соёлын салбарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;<br>- Бусад.</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | Багаар ажиллах | - Өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах ;<br>- Бусадтай итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>- Бусдын санал бодлыг анхааралтай сонсож, санал санаачлагыг дэмждэг байх;<br>- Аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх;<br>- Аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах<br>- Бусад. |
| | Бусад | - Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;<br>- Мэдээллийн технологийг албан ажилдаа бүтээлчээр хэрэглэх;<br>- Албан бичиг боловсруулах, ур чадвартай байх<br>- Кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх. |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

| | |
|---|---|
| <u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> | <u>Бусад харилцах субъект</u>:<br>- Төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан<br>- Соёлын хяналтын улсын байцаагчид<br>- Иргэн, соёл, урлагийн байгууллага |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| | |
|---|---|
| <u>Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:</u> | <u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> |
| <u>Албан тушаал</u>:<br>Захиргаа удирдлагын хэлтсийн дарга<br>С. [signature]..............(С.ШИЙЛЭГЦЭРЭН)<br>2023 оны 09 сарын 22-ны өдөр | <u>Байгууллагын нэр:</u><br>ДАРГЫН ТУШААЛ<br>Шийдвэрийн огноо: 2023.09.22<br>Дугаар: А/10 |

<u>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</u>

Байгууллагын нэр: Өвөрхангай аймгийн Соёл урлагийн газар

Шийдвэрийн огноо: 2023

Дугаар: А/10

(тамга/тэмдэг)

1022010000
3569578

СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА .................... (Д.ӨСӨХ-ЭРДЭНЭ)

2023 оны 09 дугаар сарын 22-ны өдөр